



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар Н/88

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн
хариуцсан комиссын бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1.2 дахь хэсэг, 7.6 дахь хэсэг, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 3.3.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг өөрчлөн, хавсралтаар баталсугай.


2. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд холбогдох хөрөнгийн хөдөлгөөн хийгдсэн эсэхэд хяналт тавьж, ажиллахыг комиссын дарга (Б.Болор-Эрдэнэ)-д, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр нэгтгэн танилцуулж, ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (А.Мөнгөн)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/208 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2021 оны 04 дугаар сарын
20-ны өдрийн 11/04 дугаар тушаалын хавсралт



**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН
ХАРИУЦСАН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Коммисын дарга:

Б.Болор-Эрдэнэ

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

А.Мөнгөн

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын
хэлтсийн дарга

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

С.Сэржжаргал

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн
дарга

Б.Батбаяр

Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Комиссын нарийн бичиг:

Н.Төрболд

Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн